



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/167

Мандалговь

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүнийн удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.6, аймгийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөний 4.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төслийн хүрээнд тус аймгийн төсөлд хамрагдсан сумдад гаргасан Дэлгэрцогт суманд 1 (нэг), Эрдэнэдалай суманд 1 (нэг), Сайхан-Овоо суманд (3) инженерийн хийцтэй худгийг ашиглалтад хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Эрдэнэ-Очир (ХОХБТХ-ийн дарга)

Нарийн бичгийн дарга: Ж.Батбилэг (ХХААГ-ын МҮА-ны дарга)

Гишүүд: Б.Мөнхжаргал (ХХААГ-ын дарга)
Б.Цэрэнсугир (БОАЖГ-ын мэргэжилтэн)

Ө.Дугармаа (Төслийн орон нутгийн зохицуулагч)

П.Цолмонбаатар (Дэлгэрцогт сумын Засаг дарга)

С.Мөнхбаатар (Эрдэнэдалай сумын Засаг дарга)

Б.Түвшинбаатар (Сайхан-Овоо сумын Засаг дарга)

Ц.Батбаяр (Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл)

Хоёр. Хүнс хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайд нарын 2005 оны хамтарсан тушаал болон Монгол Улсын MNS 6088:2010 стандарт "Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага"-ын дагуу хүлээн авч дүгнэлтээ танилцуулахыг ажлын хэсэг (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

Гурав. Ашиглалтад хүлээн авсан инженерийн хийцтэй худгуудыг малчдад хариуцуулж өгөхийг Дэлгэрцогт сумын Засаг дарга (П.Цолмонбаатар), Эрдэнэдалай сумын Засаг дарга (С.Мөнхбаатар), Сайхан-Овоо сумын Засаг дарга (Б.Түвшинбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010470